



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.

“Гавшгай ус” ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн.

“Гавшгай-ус” ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод хяналт сул байснаас их хэмжээний авлага, өглөг хуримтлагдаж, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж улам бүр алдагдсаар байна.

Тайланг бэлтгэсэн:
ҮАГ-ын харьяа
Сэлэнгэ аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх
Ахлах аудитор
С.Бат-Эрдэнэ

2016 оны 07 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
7036-3036 дугаарын
утас, 7036-3040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ
аймгийн Сүхбаатар
сум аймгийн ЗДТГ-
ын байрны
өргөтгөлд

Агуулга

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Хоёр. Үндсэн мэдээлэл

Гурав. Аудитын дүн

1. Эрчим хүчний тухай хуулийг зөрчин дулаанаар зохицуулалттайгаар хангах тусгай зөвшөөрөлгүйгээр дулаан дамжуулан борлуулж байгаа бөгөөд тус компаний үйл ажиллагааг аймгийн ИТХ-д тайлагнаагүй байна.

1.1 “Цемент шохой” ХХК-ийн үйлдвэрлэсэн дулааныг дулаанаар зохицуулалттайгаар хангах тусгай зөвшөөрөлгүйгээр дамжуулан борлуулж байна.

1.2 ТУЗ болон аймгийн Засаг дарга, ОНӨА-ны зүгээс компаний бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитоор үнэлэх ажил хангалтгүй байна.

1.3 Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн дотоод хяналт, шалгалт үр нөлөө муутай байна.

2. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт алдагдснаас хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулж, авлага, өглөг их хэмжээгээр өссөн байна.

2.1 Орлогыг хэрэглэгчийн тоо, талбайн хэмжээ, үнэ тариф зэргийг харгалзан үндэслэлтэй төлөвлөж байгаа боловч төлбөрийг бүрэн төвлөрүүлж чадахгүй байна.

2.2 Төлөвлөсөн зардлыг нийт дүнгээр хэмнэсэн боловч арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зардлыг бууруулах шаардлагатай байна.

2.3 Авлага, өглөгийг бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүйгээс өмнөх оноос авлага 54.4 хувиар, өглөг 30.4 хувиар тус тус өсч байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл үүссэн байна.

3. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, эргэлтийн хөрөнгийг хуулийн хугацаанд тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

3.1 Худалдан авах үйл ажиллагааны хууль, тогтоомжуудыг зөрчин босго үнээс давсан шатахуун, нүүрс, автомашины худалдан авалтуудыг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэсэн байна.

3.2 Бараа материал, үүний дотор сэлбэг хэрэгслийг 3 орчим жилийн хэрэгцээгээр нөөцөлсөн байна.

3.3 Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шугам, сүлжээний угсралтын ажлыг бүртгэлд тусгаагүй, эргэлтийн хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Илрүүлсэн зөрчил

Аудитын дүгнэлт

Зөвлөмж

Хавсралтууд

Холбогдох байгууллагын санал

Товчилсон үгийн тайлбар

ХХК	Хязгаарлагдмал хариуцлагтай компани
МУ	Монгол Улс
СЭАГ	Сэлэнгэ аймгийн Аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
НӨАТ-	Нэмэгдсэн өртгийн албан татвар
МУ	Монгол улс
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл.
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ШТС	Шатахуун түгээх станц
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.Аудитын нэр: “Гавшгай ус” ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн

2.Аудитын код: СЭАГ-2016/01-ГА

3.Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

4.Аудитын зорилт:

Сэлэнгэ аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
- ❖ Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?
- ❖ Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

5.Аудитын хамрах хүрээ:

Аудитаар “Гавшгай ус” ХХК-ийн 2015, 2016 оны 1-5 сар хүртэлх байгууллагын үйл ажиллагааны болон санхүү, аж ахуйн баримтуудыг хамруулан шалгав.

6.Аудитын арга зүй:

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн дарга, захирал, нягтлан бодогчид, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

7.Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа, аудит хийх бүрэлдэхүүн

Аудитад орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шалгуур үзүүлэлт болгохоос гадна дараах үзүүлэлтийг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- ТБОНӨХБАҮХАТ хууль
- ААНОАТ-ын тухай хууль
- НӨАТ-ын тухай хууль
- Компаний тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд болон Сангийн сайдын 2012 оны 77-р тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам” зэргийг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

8. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 07 дугаар сарын 23-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

9.Үндсэн мэдээлэл:

“Гавшгай ус” ХХК нь анх 1983 онд Хөтөлийн Цемент шохойн үйлдвэрийн харьяа Ус хангамж, ариутгах татуургын алба нэртэйгээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 78 дугаар тогтоолоор зохион байгуулалтын өөрчлөлт хийж орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болсон байна.

Тус компани нь Сайхан сумын төв дэх 8000 гаруй оршин суугчид Номгон тосгоны 2000 гаруй иргэд болон 80 гаруй аж ахуй нэгжийг цэвэр усаар хангах, аж ахуй нэгж байгууллагын ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж цэвэрлэх үндсэн үүрэг хүлээн үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Үйлдвэрлэлийн хүчин чадлын хувьд Орхон-Хөтөл гэсэн 4 өргөлт бүхий насосны станц 18.9 км урт ус дамжуулах шугамтай хоногт 6000 м³ ус олзборлох хүчин чадалтай, мөн 3000 м³ бохир шингэнийг татан зайлуулж цэвэрлэх биологи цэвэрлэгээний байгууламж, Хөтөл хотын доторх 12 км урт дулааны шугам сүлжээ, 9.4 км хэрэгцээний усны шугам сүлжээ, Номгон тосгоны 5.8 км шугам сүлжээ нийт 349 гаруй худаг камертай байна. Мөн 3200 м² ашигтай талбай бүхий 26 ш 5 давхар орон сууцны барилгын сантехникийн систем, тоног төхөөрөмж, шугам хоолойны ашиглалтын засвар үйлчилгээг хариуцан Ашиглалтын алба, засвар үйлчилгээний алба, Номгон халаалтын төв, Захиргаа санхүүгийн санхүүгийн алба гэсэн 4 нэгж, 103 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

“Гавшгай ус” ХХК-ийн хөрөнгө, мөнгийг захиран зарцуулах 1-р гарын үсгийг гүйцэтгэх захирал Л.Балдорж, 2-р гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч О.Буянаа нар зурж байна.

Тус компани нь 2015 онд 1,797,307.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,662,172.5 мянган төгрөгийн зардал гарган 121,621.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Бүлэг-1: Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна үү?

Эрчим хүчний тухай хуулийг зөрчин дулаанаар зохицуулалттайгаар хангах тусгай зөвшөөрөлгүйгээр дулаан дамжуулан борлуулж байгаа бөгөөд тус компанийн үйл ажиллагааг аймгийн ИТХ-д тайлагнаагүй байна.

1.1 “Цемент шохой” ХХК-ийн үйлдвэрлэсэн дулааныг дулаанаар зохицуулалттайгаар хангах тусгай зөвшөөрөлгүйгээр дамжуулан борлуулж байна.

1.1.1 Иргэний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4.2, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтуудыг үндэслэн Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2005 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Гавшгай ус” ХХК-ийн дүрмийг баталсан байна. Дүрмээр компанийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

- ❖ Сайхан сумын албан газар, аж ахуйн нэгж, хүн амыг цэвэр усаар хангах, аж ахуйн нэгж байгууллагын аж ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж цэвэрлэх үйл ажиллагаа явуулна;
- ❖ Иргэдэд халуун ус, зочид буудал, үсчин гоо сайхан, дулаан гражаар үйлчилж гадаад дотоод худалдаа эрхлэн, иргэдийн эрэлт хэрэгцээ, зах зээлийн шаардлагад нийцүүлэн ажиллана;
- ❖ Ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, засвар үйлчилгээг график төлөвлөгөөтэй хийж, хэрэглэгчдээс гарсан санал хүсэлтийг цаг тухайд нь барагдуулж ажиллана;

1.1.2 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-12.2.13 –д заасан тусгай зөвшөөрлүүдийг 2014 оны 08-р сарын 26-ны өдөр олгосон байна.

1.1.3 Гавшгай ус” ХХК нь 2015 оны байдлаар Сайхан сум дахь 144 аж ахуйн нэгж байгууллага, 1200 өрх айл, нийт 1344 хэрэглэгчдийг цэвэр усаар хангах ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж цэвэрлэх, Номгон тосгоны төр, төсвийн байгууллагуудыг дулаанаар хангах үйлчилгээ явуулж нийт 5,082.0 м³ цэвэр ус олборлож, 1,080.0м³ бохир шингэн татан зайлуулж, 1334.9 ккал эзэлхүүнийг дулааны эрчим хүчээр ханган ажилласан байна.

1.1.4 “Гавшгай-Ус” ХХК нь компанийн дүрэмд заагдаагүй “Цемент шохой” компанийн үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчийг айл өрхүүдэд дамжуулан борлуулах үйл ажиллагааг дулаанаар зохицуулалттайгаар хангах тусгай зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэж байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4¹, Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1², 17 дугаар зүйлийн 17.1³ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.1.5 “Цемент шохой” компани нь өөрийн үйлдвэрлэсэн дулаан, халуун усны төлбөрийг сарын эцэст Гавшгай-Ус компаниас нийт дүнгээр нэхэмжлэн, орлого төвлөрсөн эсэхээс үл хамааран төлбөрийг хоорондын тооцоогоор суутган тооцдог боловч айл, өрх, аж ахуйн нэгжүүд төлбөрөө хугацаандаа төлдөггүй нь “Гавшгай – Ус” ХХК-ийн авлагыг нэмэгдүүлж улмаар санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

1.1.6 Хөдөлмөрийн дотоод журмыг удирдах зөвлөлийн 2010 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 03 дугаар тогтоолоор 11 бүлэг 78 зүйл заалттайгаар баталсан ба 2016 оны 05-р сарын сарын 17-ны өдрийн 02 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

1.1.7 Тус компани нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2010 онд боловсруулан бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж ирсэн боловч НББОУС болон холбогдох хууль, эрх зүйн өөрчлөлтүүдээр шинэчлэлт хийгээгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 –д “ *Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.1.8 2004 оноос хойш ашиглаж байгаа “Түшиг” санхүүгийн программ нь улирал болон жилийн эцсийн санхүүгийн тайланг алдаатай нэгтгэж гаргадаг, журналууд нь Excel программ руу хөрвөдөггүй, мөнгөн хөрөнгийн журналуудыг хэвлэхэд гүйлгээний он, сар, өдрийг зөрүүтэй гаргадаг зэрэг нь бүртгэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Иймд байгууллагын бүртгэлийн үйл ажиллагааны онцлогт тохирсон санхүүгийн програм хангамжийг ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

1.2 ТУЗ болон аймгийн Засаг дарга, ОНӨА-ны зүгээс компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитоор үнэлэх ажил хангалтгүй байна.

¹ Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагын бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ

² Хуулийн этгээд дараахь үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ”, 12.1.8-д “эрчим хүчээр зохицуулалттай хангах

³ Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулаан худалдан авах, цахилгаан импортлох, цахилгаан, дулааныг хэрэглэгчид худалдах эрхийг олгоно

1.2.1 “Гавшгай-ус” ХХК-нь байгууллагын хэтийн зорилтыг тодорхойлсон стратеги төлөвлөгөөг боловсруулж мөрдөөгүй, аймгийн Засаг дарга болон Орон нутгийн өмчийн албатай үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнүүлээгүй, үйл ажиллагаагаа тайлагнаагүй байна.

1.2.2 “Гавшгай–Ус” ХХК-ийн гүйцэтгэх удирдлагаас байгууллагын бизнес төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-өөр батлуулж ирсэн байна. Гэвч гүйцэтгэх удирдлагаас оруулсан бизнес төлөвлөгөөний төсөлд ТУЗ-ийн зүгээс ямар нэгэн өөрчлөлт, санал оруулалгүйгээр шууд баталснаас үзэхэд орлого нэмэгдүүлж, зардал бууруулах, авлага, өглөгийг барагдуулж үйл ажиллагааг сайжруулах удирдлага, зохион байгуулалт, менежментийн өөрчлөлт хийх талаар ТУЗ ажиллаагүй байна гэж үзэж байна.

1.2.3 Байгууллагын дотоод журмын 4.1.3-д *“бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнана”* гэж заасан боловч төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр дүгнээгүй байна.

1.2.4 ТУЗ-ийн 2015 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 01 тоот тогтоолоор 2015 оны нийт орлогыг 1,608,539.4 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,593,539.4 мянган төгрөгөөр, 2015 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 05 тоот тогтоолоор 2016 оны нийт орлогыг 1,538,025.4 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,526,025.3 мянган төгрөгөөр тус тус хянаж баталсан байна.

1.2.5 ТУЗ нь 2016 оны 05-р сарын 17-ны өдрийн хурлаар компанийн 2015 оны санхүүгийн гүйцэтгэлийг хэлэлцээд **хангалттай сайн** гэж дүгнэсэн нь авлага, өглөг эрс өссөн, бэлэн мөнгөний эргэлт багассан, цаашид үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх нөхцөл боломж алдагдсан бодит байдалтай нийцэхгүй байгаа бөгөөд үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнгийн талаарх тайланг Аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлээгүй байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-д *“Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана”*, 96.5 –д *“Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ”* гэсэн заалтуудыг зөрчиж байна.

1.2.6 2015 онд Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2014 оны үйл ажиллагааны үр дүн тайланг хэлэлцэж, 2015 оны 04-р сарын 22-ны өдрийн 50 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн ТУЗ, гүйцэтгэх захирал нарт дараах үүрэг даалгаврыг өгсөн байна. Үүнд:

- Байгууллагынхаа бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааны менежментээ сайжруулан зардлаа хэмнэж, өр авлагаа бууруулах талаар идэвх санаачилга гарган ажиллах,
- Иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээ бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, чанар хүртээмжийг дээшлүүлэн хэрэглэгчийн тоог өсгөх замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх,

- Цэвэр усны төвлөрсөн шугамд холбогдсон айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад усны тоолуур суурилуулж бодит хэрэглээгээр өр төлбөрийг тооцох, усны алдагдлыг бууруулах,

Мөн аймгийн Засаг даргад орон нутгийн өмчит үйлдвэрийн газар компаниудтай холбоотой олон жил хуримтлагдсан өр, авлагыг барагдуулах арга замыг судлан холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн шийдвэрлэх, зайлшгүй шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмж, их засварын зардлыг аймаг орон нутгийн жил бүрийн төсөвт ээлж дараатай тусган шийдвэрлэх, ТУЗ-ийг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх санал боловсруулж аймгийн ИТХТ-ийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, “Гавшгай ус” ХХК-ийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагаар эдийн засгийн үнэлгээ шинжилгээ хийлгэж, тус компаний төсвийн алдагдлыг бууруулж ашигтай ажиллуулах арга замыг судлан тусгай төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхийг тус тус даалгасан боловч аймгийн Засаг даргын зүгээс хэрэгжүүлээгүй байна.

1.2.7 Дээрх тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт болон 2015 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн дүгнэлтийг аймгийн ИТХТ-ийн хурлаар дахин хэлэлцээгүй байгаагаас үндэслэн Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна гэж үзэж байна.

1.2.8 Компанийн захирал, удирдлагуудад зөвхөн санхүүгийн тайлангаар тайлагнагдсан, бэлэн мөнгө нь орж ирээгүй борлуулалтын орлого, ашгийг үндэслэн ажлыг нь үнэлж, ашгаас бодон урамшуулал олгож буй гаж тогтолцоог өөрчилж авлага, өглөг барагдуулалт, компанийн санхүүгийн чадвар, хэвийн үйл ажиллагааг харгалзан урамшуулал олгож, ажлыг нь дүгнэж байх нь зүйтэй юм.

1.3 Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн дотоод хяналт, шалгалт үр нөлөө муутай байна.

1.3.1 “Гавшгай- Ус” компанийн 2014 он, 2015 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийсэн байна. Уг шалгалтаар мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх зөрчилгүй ажилласан гэж дүгнэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байна. Хяналт, шалгалтаар дараах зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгуудыг дэлгэрэнгүй бэлтгэж тайлагнах,
- НББОУС 21 дүгээр стандартын дагуу шинэчлэгдсэн маягыг бүрэн хөтөлж анхан шатны баримтыг зохих заавар журмын дагуу хөтөлж ажиллах,
- Авлага, өглөгийг барагдуулсны үндсэн дээр эргэлтийн хөрөнгийн эргэцийг сайжруулан байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үр ашигтай хэмжээнд хүргэх,
- Хяналт шалгалтаар орон нутгийн өмч хөрөнгийг зүй бус зарцуулсан зөрчил гараагүй боловч санхүүгийн үйл ажиллагааг цэгцтэй болгох, дүгнэлт

шинжилгээг оновчтой, ирээдүйд чиглэсэн үзүүлэлтүүдийг тооцдог болох гэсэн зөвлөмжүүдийг өгсөн байна.

1.3.2 Гэвч гүйцэтгэлийн аудитын явцаас үзэхэд авлага, өглөгийг бууруулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгуудыг дэлгэрэнгүй бэлтгээгүй байгаа нь компанийн удирдлагууд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна гэж дүгнэхэд хүргэж байна.

1.3.3 “Гавшгай ус” ХХК-ийн ТУЗ нь 6 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 2015 онд 2 удаа, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 1 удаа хуралдахдаа тухайн оны бизнес төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг хэлэлцэх, байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулах, ТУЗ-ийн урамшуулалд өөрчлөлт оруулах, гүйцэтгэх захирлын цалинг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудыг хэлэлцсэн бөгөөд компаний өмнө тулгараад буй санхүүгийн хүндрэлийг хэрхэн даван туулах талаар огт хэлэлцээгүй байна.

1.3.4 ТУЗ нь дүрэмд заасны дагуу жилд хоёроос доошгүй удаа хуралдаж байгаа боловч дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар ямар нэг ажил зохион байгуулаагүй байна.

1.3.5 Компанийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөө муутай байна.

Бүлэг-2: Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?

Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт алдагдснаас хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулж, авлага, өглөг их хэмжээгээр өссөн байна.

2.1 Орлогыг хэрэглэгчийн тоо, талбайн хэмжээ, үнэ тариф зэргийг харгалзан үндэслэлтэй төлөвлөж байгаа боловч төлбөрийг бүрэн төвлөрүүлж чадахгүй байна.

2.1.1 Гүйцэтгэх захирлын тушаалаар жил бүр ажлын хэсэг томилон тухайн оны бизнес төлөвлөгөө боловсруулж, орлогыг нэр, төрөл бүрээр тооцоолж төлөвлөж ирсэн байна.

2.1.2 “Гавшгай ус” ХХК нь 2015 оны нийт орлогыг 1,608.539.4 мянган төгрөгөөр, 2016 оны нийт орлогыг 1,538,025.4 мянган төгрөгөөр төлөвлөж, 2015 онд 1,620,079.9 мянган төгрөгийн, 2016 оны 4-р сарын байдлаар 635,870.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагджээ.

2.1.3 2015 онд цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ, суурь хураамж нэмэгдсэнтэй холбоотойгоор 2015 оны орлогыг төлөвлөхдөө урьд оноос 30.6 хувиар өсгөж төлөвлөсөн байна

Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

хүснэгт -1 мян.төг

үзүүлэлт	2013 он		2014 он		2015 он		2016 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /2016.04.30 /
цэвэр ус	674,861.5	531,632.7	709,101.4	526,696.3	899,694.2	947,513.5	865,805.5	293,501.7
Бохир ус	275,284.2	245,490.5	272,086.1	240,914.4	413,902.2	394,266.5	390,611.0	143,270.8
Дулаан	97,320.1	98,079.3	111,942.7	111,945.1	111,942.8	112,776.5	113,885.1	136,671.2
Шугам ашиглалт	82,950.0	84,364.9	86,425.5	98,315.1	101,187.3	108,381.6	101,187.3	60,622.4
Суурь хураамж			-	-	48,052.9	49,282.6	43,536.6	784.0
Бусад орлого	8,700.0	13,453.8	52,455.8	27,016.5	33,760.0	7,859.2	23,000.0	1,020.5
Нийт дүн	1,139,115.8	973,021.2	1,232,011.5	1,004,887.4	1,608,539.4	1,620,079.9	1,538,025.4	635,870.6

2.1.4 Хүснэгтээс үзэхэд орлогын төлөвлөгөө 2013 онд 85.4 хувь, 2014 онд 81.6 хувь, 2015 онд 101,0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна. 2015 оны орлогын гүйцэтгэлийн 62.8 хувийг “Цемент шохой” ХХК, 3.4 хувийг төсвийн байгууллагууд, 5.8 хувийг бусад аж ахуй нэгж байгууллагууд, 28 хувийг төвлөрсөн орон сууцны оршин суугчдаас төвлөрүүлсэн байна.

2.1.5 “Гавшгай ус” ХХК-ийн борлуулалтын орлого жил бүр нэмэгдэж байгаа боловч хэрэглэгчдээс авах авлага буураагүй байна.

2.1.6 НББОУС-ын дагуу орлого, зарлагыг аккрузл сууриар тооцож, цуглуулагдаагүй авлага нь борлуулалтын орлогоор бүртгэгдэж байгаа тул борлуулалтын орлого жил бүр нэмэгдсэн ч борлуулсан бүтээгдхүүний төлбөрийг бүрэн цуглуулж чадахгүй, авлага нэмэгдэж , бэлэн мөнгөний хомсдолд орж байна.

2.2 Төлөвлөсөн зардлыг нийт дүнгээр хэмнэсэн боловч арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зардлыг бууруулах шаардлагатай байна.

2.2.1 “Гавшгай –ус” ХХК нь бизнес төлөвлөгөөгөөр 2014 онд 1,227,011.5 мянган төгрөгийн, 2015 онд 1,608,539.4 мянган төгрөгийн, 2016 онд 1,538.025.5 мянган төгрөгийн зарлага гаргаж ажиллахаар төлөвлөж, 2014 онд 1,325,818.5 мянган төгрөгийн, 2015 онд 1,484,944.6 мянган төгрөгийн 2016 оны 4-р сарын байдлаар 521,275.5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

2.2.2 2015 оны зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 7.6 хувиар бага бол 2014 оны гүйцэтгэлээс 159,126.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

хүснэгт- 2 мян.төг

Үзүүлэлт	2015.12.31			2016.04.30			
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө /жилээр/	төлөвлөгөө /2016.04.30/	гүйцэтгэл	зөрүү
Үндсэн цалин, нэмэгдэл цалин	631,539.2	566,459.8	65,079.4	621,860.6	207,286.8	226,543.4	(19,256.60)
НДШ	79,760.0	72,896.4	6,863.6	80,841.8	26,947.2	30,356.1	(3,408.90)
Цахилгааны зардал	323,650.6	339,800.1	(16,149.5)	325,000.0	108,333.3	114,614.2	(6,280.90)
Дулааны зардал /Нүүрс/	55,000.0	52,668.1	2,331.9	42,000.0	18,000.0	16,500.0	1,500.00
Шатахуун тээврийн зардал	56,000.0	50,551.6	5,448.4	50,000.0	16,500.0	16,356.5	143.50
Сэлбэг, засвар үйлчилгээ	139,600.0	130,616.5	8,983.5	128,000.0	42,600.0	34,555.6	8,044.40
Хангамжийн зардал	37,000.0	32,029.8	4,970.2	16,023.1	5,300.0	5,200.0	100.00
Хөдөлмөр хамгааллын зардал	31,503.1	29,574.4	1,928.7	31,000.0	10,000.0	8,400.0	1,600.00
Албан томилолтын зардал	11,800.0	13,399.0	(1,599.0)	13,000.0	4,300.0	3,600.0	700.00
Бичиг хэрэг				5,000.0	1,600.0	1,550.0	50.00
Шуудан холбоо				6,900.0	2,300.0	1,849.0	451.00
Цэвэрлэгээний материал				6,000.0	2,168.0	2,056.4	111.60
Хөнгөлөлт	28,600.0	31,811.9	(3,211.9)	25,000.0	8,300.0	7,900.0	400.00
Уралдаан тэмцээн	12,000.0	11,959.3	40.7	11,000.0	3,600.0	3,400.0	200.00
Сургалт	8,800.0	7,530.5	1,269.5	8,800.0	2,900.0	2,650.0	250.00
Баяр ёслол	16,000.0	14,491.4	1,508.6	14,000.0	4,600.0	4,400.0	200.00
Шагнал урамшуулал	12,000.0	9,250.3	2,749.7	12,000.0	4,000.0	3,480.0	520.00
ТУЗ-ийн зардал	18,486.5	5,910.0	12,576.5	18,000.0	18,000.0	2,445.9	15,554.10
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	76,800.0	78,764.6	(1,964.6)	78,000.0	26,000.0	26,922.4	(922.40)
Зохицуулах үйлчилгээний хөлс	7,000.0	6,527.5	472.5	6,600.0	2,200.0	-	2,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	18,000.0	16,528.2	1,471.8	12,000.0	4,000.0	3,680.0	320.00
бусад	30,000.0	14,175.2	15,824.8	15,000.0	5,000.0	4,816.0	184.00
Төсөвлөсөн ашиг	15,000.0	-	15,000.0	12,000.0			-
Нийт дүн	1,608,539.4	1,484,944.6	123,594.8	1,538,025.5	523,935.3	521,275.5	2,659.80

2.2.3 2015 оны нийт зардлын 43 хувийг боловсон хүчний зардал, 22.9 хувийг ашиглалтын зардал, 19.9 хувийг хангамж, материалын зардал, 5.3 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 26.9 хувийг бусад зардлууд эзэлж байна.

2.2.4 Төлөвлөснөөс цахилгааны зардал 16,149.5 мянган төгрөгөөр, албан томилолтын зардал 1,599.0 мянган төгрөгөөр, ажилтнуудад олгож буй хөнгөлөлт чөлөөлөлтийн зардал 3,211.9 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 1,964.6 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна. Харин цалин, НДШ-ийн зардал 71,943.0 мянган төгрөгөөр, нүүрс, шатахуун, сэлбэг, хангамжийн материал, хөдөлмөр хамгааллын зардлууд 23,662.7 мянган төгрөгөөр, бусад зардлууд 35,914.1 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

2.2.5 Үйл ажиллагааны зардлыг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан эсэхийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

А /Компанийн үйл ажиллагаанд хамааралгүй, хандивын шинжтэй дараах **4,090.1** мянган төгрөгийн зөрчлийг гаргасан байна. Тухайлбал:

- Бумбаны баярын үйл ажиллагаанд 600.0 мянган төгрөг,
- н.Отгонбаатар шүлгийн ном 200.0 мянган төгрөг, /70ш*6.5-455.0 мянган төгрөг/
- Ё.Батцэнгэл шүлгийн ном 600.0 мянган төгрөг, /90ш *8.0 -720.0 мянган төгрөг/

- Н.Болд “цагийн аяс” CD-ний үнэ 250.0 мянган төгрөг, /30ш*20.0-600.0 мянган төгрөг/
- Холбогдох байгууллагаас албан томилолтоор ажиллаж байгаа хүмүүсийг хоолонд оруулахад 2015 онд 2,264.1 мянган төгрөгийг, 2016 оны 1-4 сард 176.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна./дэлгэрэнгүйг хавсралт 1-д үзүүлэв/

Б/ Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар нийт 4,650.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна./дэлгэрэнгүйг хавсралт 2-д үзүүлэв / Эдгээр зөрчил нь НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.7⁴ дахь заалтуудыг зөрчиж байна.

В/ Ажилтнуудад албан томилолтын зардлыг олгохдоо “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчилэн тогтоох” тухай Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалыг зөрчин албан томилолтын үнэмлэх, томилолтоор ажилласан эсэхийг нотлох, дэмжих баримтгүйгээр **3,253.3** мянган төгрөгийг, зам хоног, байрны зардал олгосон боловч нэмж зочид буудлын зардлыг **1,905.1** мянган төгрөгөөр илүү олгосон байна./дэлгэрэнгүйг хавсралт 3-д үзүүлэв/

2.2.6 Тус компанийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, татвар, НДШ-ийн их хэмжээний өглөгтэйгээс харилцах данс хаагддаг, орж ирсэн орлогыг тухайн байгууллагууд шууд татаж авдгаас шалтгаалан мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээний дийлэнх хувь нь кассаар дамжин хийгдсэн байна.

2.2.7 Энэ нь мөнгөн хөрөнгийн зарцуултад бүртгэлээр тавих хяналт сулрах, анхан шатны баримтгүй, үр ашиггүй зардал гарах эрсдлүүдийг бий болгож байна.

2.3 Авлага, өглөгийг бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүйгээс өмнөх оноос авлага 54.4 хувиар, өглөг 30.4 хувиар тус тус өсч байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл үүссэн байна.

Авлагын талаар:

2.3.1 “Гавшгай-ус” ХХК нь 2015 оны жилийн эцэст 1,038,438.7 мянган төгрөгийн, 2016 оны 4-р сарын байдлаар 1,175,052.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь 2014 оныхоос 277,474.6 мянган төгрөгөөр буюу 36.5 хувиар, 2015 оны жилийн эцсийн үлдэгдлээс 136,613.6 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар тус тус өссөн байна.

2.3.2 Үйл ажиллагаа явуулж, борлуулалт хийх тусам авлага дагаж нэмэгддэг сөрөг үр дагаварт хүрч, энэ нь тус компанийн хамгийн тулгамдсан асуудал болсон байна. Өөрөөр хэлбэл тус компани нь бүтэн нэг жилийн борлуулалтын орлогоо төвлөрүүлж чадахгүй, энэ хэмжээгээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эргэлдэх мөнгөн хөрөнгө дутагдаж байна гэсэн үг юм. /2015 оны борлуулалтын орлого 1,068,539.4 мянган төгрөг бол 2016 оны эхний 4 сарын байдлаарх авлага 1,175,052.3 мянган төгрөг /

⁴ 7.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 7.7. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно.

Авлагын үлдэгдэл дансны төрлөөр

хүснэгт- 3 мян.төг

Дансны төрөл	2015.12.31				2016.04.30		
	эхний	нэмэгдсэн	хасагдсан	Эцсийн үлдэгдэл	нэмэгдсэн	хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Усны авлага	197,618.8	1,661,621.7	1,475,863.2	383,377.3	588,031.9	517,991.9	453,417.3
Байгууллагын авлага	89,092.5	21,018.3	18,480.4	91,630.4	3,272.0	2,282.4	92,620.0
Цалингийн авлага	21,724.4	12,266.2	12,040.4	21,950.1	4,745.7	2,312.0	24,383.8
Оршин суугчдын усны авлага	337,751.6	374,580.0	283,268.6	429,062.9	150,371.5	86,745.9	492,688.4
Хүмүүсийн авлага	35,353.8	3,632.1	8,445.1	30,540.7	34.3	-	30,575.0
Дараа тайлангийн авлага	2,250.0	8,931.7	8,931.7	2,250.0	549.9	404.1	2,395.8
Ажиллагсдын өр	77,153.1	26,881.8	25,857.1	78,177.8	4,942.9	5,598.2	77,522.6
Бусад	20.0	3,216.0	2,256.2	979.8	-	-	979.8
ААНОАТ	-	751.2	281.7	469.5	-	-	469.5
Нийт дүн	760,964.1	2,112,899.0	1,835,424.4	1,038,438.7	751,948.1	615,334.5	1,175,052.3

2.3.2 2016 оны 4-р сарын байдлаарх нийт авлагын 81 хувийг борлуулалтаас үүссэн авлага, 8 хувийг байгууллагаас авах, 3 хувийг хувь хүмүүсээс авах, 9 хувийг ажиллагсдаас авах, 0.1 хувийг бусад авлага эзэлж байна.

2.3.3 Авлагыг насжилтаар нь ангилж бүртгээгүй байсан бөгөөд аудитын явцад 2016 оны 4-р сарын байдлаарх 1,175,052.3 мянган төгрөгийн авлагын 58 хувь буюу оршин суугчдын усны авлагаас бусад авлагын дүнд насжилтийн судалгааг гаргуулан харьцуулалт хийж үзэхэд дараах байдалтай байна.

Авлагын насжилт жилээр

хүснэгт- 4 мян.төг

Дансны төрөл	Хугацаа				Нийт дүн
	1998-2004	2005-2010	2011-2014	2015-2016	
Байгууллагын авлага	14,914.1	52,297.3	16,283.7	9,124.9	92,620.0
Хүмүүсийн авлага	23,526.9	4,207.4	875.0	1,965.8	30,575.1
Ажилчдаас авах авлага	13,204.2	46,320.6	17,676.3	321.5	77,522.6
Цалингийн авлага	-	-	17,947.8	6,436.1	24,383.9
Усны авлага	-	48,959.4	130,664.3	273,793.7	453,417.3
Дараа тайлангийн авлага	-	-	2,250.0	145.8	2,395.8
Бусад авлага	-	-	20.0	1,429.3	1,449.3
Нийт дүн	51,645.2	151,784.7	185,717.1	293,217.1	682,364.0
Эзлэх хувь	7.57	22.24	27.22	42.97	100.00

2.3.4 Нийт авлагын 17 хувийг 10-18 жилийн өмнөх авлага, 15.6 хувийг 2 жилээс дээш авлага, 25 хувийг 1-2 жилийн хугацаатай авлага тус тус эзэлж байна. Иймд авлагын дэлгэрэнгүй судалгаа хийж, эзэн, хариуцагч нь тодорхой авлагуудыг ойрын хугацаанд барагдуулан энэ хэмжээгээр өглөгийг бууруулах боломжтой юм.

2.3.5 Кампанийн удирдлага, бүртгэл тооцооны ажилтнуудын зүгээс хөрөнгө, санхүүгийн нөөцийг зохистой удирдаагүй, бүртгэлээр тавих хяналт сул байснаас нийт авлагын 27 % буюу 315.229.3 мянган төгрөгийг борлуултын орлогоос үүссэн бус байгууллага, хувь хүн, ажилчдын хоорондын тооцооноос авах , барагдуулах бүрэн боломжтой авлагууд эзэлж байна. Тухайлбал:

- Байгууллагаас авах авлагын дансанд бүртгэлтэй 92,619.9 мянган төгрөгийн авлага нь 1998-2015 оны хооронд 39 аж ахуйн нэгж байгууллагад “Цемент шохой” ХК-ийн хоорондын тооцоогоор цемент, шохой бусад бараа материал борлуулснаас үүссэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-д үзүүлэв/
- Хувь хүмүүсээс авах авлагын дансанд бүртгэлтэй 30,574.9 мянган төгрөгийн авлага нь 1997-2015 оны хооронд цемент борлуулах болон жолооны курсын төлбөрийн, бараа материалын борлуулалтаас үүссэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5-д үзүүлэв/ Үүнээс 23,985.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй 26 иргэн, 31,971.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй 11 аж ахуйн нэгж байгууллагын хаяг байршил тодорхой бус гэсэн судалгаа хийсэн байна.
- Ажилчдаас авах авлагын дансанд бүртгэлтэй 77,522.6 мянган төгрөгийн авлага нь 1998-2016 оны хооронд ажилтнуудад олгосон цемент, хүнсний материал, дотоод журмын дагуу олгож байсан хөнгөлөлт чөлөөлөлтөөс үүссэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 6-д үзүүлэв/ Үүнээс 41.4 хувь буюу 32,091.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй 42 хүн ажлаас чөлөөлөгдсөн, 58.6 хувь буюу 45,431.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй 48 хүн нь одоо ажиллаж байна.
- Ажилчдаас авах цалингийн авлагын дансанд бүртгэлтэй 22,326.8 мянган төгрөгийн авлага нь 2011-2016 оны хооронд олгосон цалингийн урьдчилгааг дутуу суутгаж ирснээс хуримтлагдсан байна. Үүнээс 7,429.0 мянган төгрөгийн авлагатай 8 ажилтан нь ажлаас чөлөөлөгдсөн бөгөөд хаяг нь тодорхой бус байна. Цалингийн урьдчилгааг тайлант жилд багтаан суутгаж ирээгүйгээс нийт 21 хүний 10.0-6,137.8 мянган төгрөгийн өр хуримтлагдсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 7-д үзүүлэв/
- Байгууллагуудад борлуулсан бүтээгдхүүнээс авах авлагын дансанд бүртгэлтэй 453,417.3 мянган төгрөгийн авлагын дүнд 2010-2016 оны хооронд 12 аж ахуйн нэгж байгууллагад цемент борлуулсан 92,185.1 мянган төгрөгийн авлагыг бүртгэсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 8-д үзүүлэв/ Байгууллагаас авах борлуулалтын орлогын авлагын 31 хувийг Цемент шохой” ХХК-аас авах авлага эзэлж байна.

2.3.6 Авлагын дансанд авлага барагдуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий тус компанийн удирдах албан тушаалтнууд болон санхүү, бүртгэлийн ажилтнуудаас авах авлага ч тодорхой хувийг эзэлж байна. Тухайлбал:

- Ерөнхий нягтлан бодогч О.Буянаа 1,530.2 мянган төгрөгийн, нягтлан бодогч М.Оюун 1,883.4 мянган төгрөгийн, кассын нярав М.Оюунбаяр 6,137.2 мянган төгрөгийн зэрэг 2012-2015 онд үүссэн нийт 9,550.8 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагыг барагдуулаагүй байна.

-Ерөнхий нягтлан бодогч О.Буянаагийн 2009 онд үүссэн 4,056.8 мянган төгрөгийн хүнс, цементний, кассын нярав М.Оюунбаярын 2012 онд үүссэн 6,893.3 мянган төгрөгийн хүнс, цементний, ерөнхий инженер С.Хамсандоржийн 2012 онд үүссэн 3,763.5 мянган төгрөгийн цементний, хүний нөөцийн ажилтан Д.Лхагвасүрэнгийн 2007 онд үүссэн 3,316.4 мянган төгрөгийн зэрэг нийт 18,030.0 мянган төгрөгийн авлагуудыг өнөөг хүртэл барагдуулаагүй байна.

2.3.7 “Гавшгай-Ус” ХХК компанийн гүйцэтгэх захирал Л.Балдорж, тооцооны нягтлан бодогч М.Оюун, И.Цэвэлмаа зэрэг удирдах болон бүртгэлийн ажилтнууд нь 10 гаруй жил тогтвор суурьшилтай албан тушаал хашиж байгаа бөгөөд ямар авлага хэдэн онд үүссэн, хариуцах эзэн, холбогдогч нь хэн болохыг тодорхой мэдэж байгаа боловч авлага барагдуулах талаар санаачлага гаргаж ажиллаагүй, өөрөөр хэлбэл компанийн хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжийг алдагдуулж буй авлагын асуудал нь захирал, бүртгэл тооцооны ажилтнуудын ажлын хариуцлагагүй байдлаас үүссэн гэж дүгнэж байна.

2.3.8 Аймгийн Аудитын газраас 2010, 2013 онд хийж гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитуудаар тус компанийн хамгийн тулгамдсан асуудалд болох авлагыг барагдуулж ажиллах зөвлөмжийг захирал Л.Балдорж, ерөнхий нягтлан бодогч О.Буянаа нарт өгч байсан боловч хэрэгжүүлээгүйгээс 2009 онд 542,519.3 мянган төгрөг, 2013 онд 758,503.6 төгрөг байсан авлагууд 2016 оны эхний 4 сарын байдлаар 1,175,052.3 мянган төгрөгт хүрч огцом нэмэгдсэн байна.

2.3.9 Гүйцэтгэх захирлын 2015 оны 06-р сарын 02-ны өдрийн 37 тоот тушаалаар “Авлага бууруулах ажил зохион байгуулах” тухай шийдвэр гаргасан байна. Энэ ажлын хүрээнд 2014 онд 20, 2015 онд 10 иргэнийг тус тус Шүүхийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлэсэн бол 2016 оны 4-р сард 346 айл өрхөөр орж мэдэгдэх хуудас хүргүүлэх арга хэмжээг авч, мөн хэрэглэгчийн тоог тулгаж шинээр 184 хүнийг хэрэглэгчээр бүртгэсэн байна.

2.3.10 Авлага бууруулахаар зохион байгуулж байгаа ажлууд нь тодорхой үр дүнд хүрэх, үр нөлөө бүхий ажил болж чадахгүй байгаа нь тус компанийн авлага жил ирэх бүр нэмэгдэж байгаа байдлаас харагдаж байна.

Өглөгийн талаар:

2.3.12 2015 оны жилийн эцэст 1,074,051.0 мянган төгрөгийн, 2016 оны 4-р сарын байдлаар 1,191,645.1 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь 2014 оны үлдэгдлээс 160,592.5 мянган төгрөгөөр буюу 18 хувиар, 2015 оны жилийн эцсийн үлдэгдлээс 117,594.1 мянган төгрөгөөр буюу 11 хувиар тус тус өссөн байна.

Өглөгийн үлдэгдэл дансны төрлөөр

хүснэгт-5 мян.төг

Дансны төрөл	2015.12.31				2016.04.30		
	эхний үлдэгдэл	дебет	кредит	Эцсийн үлдэгдэл	дебет	кредит	Эцсийн үлдэгдэл
Байгууллагын өглөг	56,377.2	231,735.6	222,956.5	47,598.1	43,647.1	44,573.0	48,524.0
Цалингийн өглөг	26,696.0	562,932.4	582,522.1	46,285.7	182,787.0	231,289.2	94,787.8
Оршин суугчдын өглөг	5,231.1	9,480.9	6,338.4	2,088.6	2,386.2	1,599.8	1,302.2
Бусад	4,024.1	35,536.7	39,499.1	7,986.6	3,927.3	4,476.9	8,536.2
Дараа тайлангийн өглөг	30.4	2,196.6	2,200.2	34.0	-	-	34.0
ААХ-ийн өглөг	4,189.8	5,912.6	7,736.0	6,013.2	1,401.3	16,118.0	20,729.9
ОНО -ийн	7,812.7	-	-	7,812.7	-	-	7,812.7
Ноогдол ашгийн татвар	1,951.1	-	0.1	1,951.2	-	18,243.3	20,194.5
Бусад	5,891.7	12,244.2	6,352.5	-	-	153.2	153.2
НӨАТ	231,374.8	126,573.3	181,791.4	286,592.9	94,224.6	63,507.7	255,876.0
ХАОАТ	138,706.9	19,916.3	43,473.8	162,264.4	-	17,611.6	179,876.0
ҮХХТатвар	3,563.8	3,563.8	3,546.2	3,546.2	-	-	3,546.2
ААНОАТ	-	16,488.4	16,488.4	-	-	-	-
Тээврийн хэрэгсэл	190.6	224.6	167.4	133.4	-	-	133.4
Газар	-	1,173.4	1,173.4	-	-	-	-
Бууны татвар	-	52.5	52.5	-	-	-	-
НДШ	427,418.3	59,701.2	134,026.9	501,744.1	5,360.5	53,755.5	550,139.1
Нийт дүн	913,458.4	1,087,732.5	1,248,325.0	1,074,051.0	333,733.9	451,328.1	1,191,645.1

2.3.13 2016 оны 04-р сарын байдлаар нийт өглөгийн 4 хувийг байгууллагад төлөх өглөг, 7.9 хувийг цалингийн өглөг, 36.9 хувийг татварын өглөг, 46.2 хувийг НДШ-ийн өглөг, 5 хувийг бусад өглөг тус тус эзэлж байна.

2.3.14 Авлага барагдуулалт хангалтгүй байгаагаас бэлэн мөнгөний хомсдолд орж 2014 оны жилийн эцсийн дүнгээс өглөг 30.4 хувиар өссөн байна.Үүнд: цалингийн өглөг, НДШ, НӨАТ, ХХОАТ, ҮХХТатварын өглөгийн өсөлт голлон нөлөөлж байна.

2.3.15 “Гавшгай-Ус” ХХК нь 2015 оны жилийн эцэст ашигтай ажилласнаар тайлагнагдсан боловч их хэмжээний авлага үүссэний улмаас ажилтнуудын цалинг 2-3 сараар хугацаа хоцроон олгох, НДШ-ийг төлөхгүй өр үүсгэх, улмаар хуулийн дагуу тэтгэвэр тэтгэмж тогтоолгож чадахгүй байх, банкны хэрэглээний зээл авч чадахгүй байх зэргээр ажилтнуудын нийгмийн асуудалд сөргөөр нөлөөлж байна.

Бүлэг-3:Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, эргэлтийн хөрөнгийг хуулийн хугацаанд тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

3.1 Худалдан авах үйл ажиллагааны хууль, тогтоомжуудыг зөрчин босго үнээс давсан шатахуун, нүүрс, автомашины худалдан авалтуудыг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэсэн байна.

3.1.1 2015 онд 22,000.0 мянган төгрөгөөр өргөлтийн насос худалдан авахдаа харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийж 3 аж ахуй нэгжээс үнийн санал авсан бөгөөд хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Хөтөл мөнхийн зул” ХХК-аас худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Дараах үнийн саналууд ирүүлсэн байна. / “Цол Инержи” ХХК 27,500.0 мянган төгрөгийн, “ Хөтөл тэлмэн” ХХК 25,300.0 мянган төгрөгийн, Хөтөл мөнхийн зул” ХХК 22,000.0 мянган төгрөгийн/

3.1.2 “Цемент шохой” ХХК-д борлуулсан усны орлогыг цаг хугацаанд нь төвлөрүүлж чаддаггүй байдлаас шалтгаалан компани хоорондын тооцоогоор 133,868.4 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэхдээ үнийн харьцуулалт хийлгүйгээр шууд гэрээ байгуулсан байна. Тухайлбал:

3.1.3 “Астра интернэйшнл” ХХК-аас “Toyota Highlander” автомашиныг 44,500.0 мянган төгрөгөөр худалдан авч төлбөрийг “Цемент шохой” ХК-аас авах авлагаас суутгуулсан байна.

/ “Астра интернэйшнл” ХХК-аас худалдан авсан “Toyota Highlander” автомашин /



3.1.4 Цемент шохой” ХХК-аас 2015 онд 52,775.3 мянган төгрөгийн, 2016 оны 4-р сарын байдлаар 36,593.1 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг шууд гүйцэтгэсэн байна.

3.1.5 2015 онд 54,063.4 мянган төгрөгийн, 2016 оны 4-р сарын байдлаар 14,138.2 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэсэн байна.

3.1.6 Эдгээр зөрчлүүд нь МУ-ын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1⁵, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2 дахь⁶ заалтыг тус тус зөрчсөн байна.

⁵ Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

⁶ Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 10 сая төгрөг

3.2 Бараа материал, үүний дотор сэлбэг хэрэгслийг 3 орчим жилийн хэрэгцээгээр нөөцөлсөн байна.

3.2.1 “Гавшгай ус” ХХК нь үйл ажиллагааныхаа хэрэгцээнд зориулж 2015 онд 312,533.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 266,835.4 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн бол 2016 оны 04-р сарын 30-ны өдрийн байдлаар 83,628.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч бэлтгэн, 98,005.5 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

3.2.2 Бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг 2015, 2016.04.30-ны өдрийн байдлаар харуулбал:

хүснэгт-6 /мян.төг/

Дансны нэр	2015.12.31				2016.04.30		
	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
Химийн бодис	5,857.9	-	-	5,857.9	-	-	5,857.9
Аж ахуйн материал	13,209.9	32,039.9	33,248.9	12,000.9	1,678.0	2,058.5	11,620.4
Шатахуун	-	54,063.4	54,063.4	-	14,138.2	14,138.2	-
Тослох материал	1,045.7	504.8	1,180.9	369.7	-	150.1	219.6
Нүүрс	-	52,775.3	52,775.3	-	36,593.1	36,593.1	-
Цахилгааны сэлбэг	38,426.6	25,485.1	11,988.1	51,923.5	1,397.8	3,425.6	49,895.7
Насосны сэлбэг	128,459.4	61,078.0	51,871.2	137,666.2	9,206.3	15,365.7	131,506.8
Автын сэлбэг	1,239.9	2,404.1	2,566.1	1,077.9	180.0	-	1,257.9
Сантехникийн сэлбэг	56,921.2	25,604.6	13,772.5	68,753.3	2,322.5	4,342.3	66,733.5
Хүнсний материал	427.0	16,338.2	14,928.8	1,836.4	9,127.9	10,748.3	216.0
БҮТЭЗ	14,278.3	37,626.2	26,266.4	25,638.2	4,824.2	8,766.0	21,696.4
Ашиглалтанд байгаа БҮТЭЗ	43,873.3	3,373.8	1,232.8	46,014.3	2,503.0	668.0	47,849.3
Токарын сэлбэг	7,677.3	365.0	1,963.9	6,078.4	-	48.6	6,029.7
бусад	335.4	874.7	977.2	232.9	1,657.4	1,701.0	189.3
Нийт дүн	311,751.8	312,533.2	266,835.4	357,449.5	83,628.4	98,005.5	343,072.5

3.2.3 Бараа материалын 2015 оны үлдэгдэл нийт дүнгээр өмнөх оноос 45,697.7 мянган төгрөгөөр буюу 14.7 хувиар өссөн байна. 2015 оны жилийн эцсийн бараа материалын үлдэгдлийн 74.3 хувийг сэлбэг, 25.7 хувийг бусад хангамжийн материал эзэлж байна.

3.2.4 Бараа материалын үлдэгдлийн тайлангаас харахад үлдэгдэл жил ирэх бүр нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд / 2014 оны эцэст 311,751.3 мянган төгрөг, 2015 оны эцэст 357,449.5 мянган төгрөг / , үүний дотор сэлбэгийн үлдэгдэл жилийн хэрэгцээнээс хэт илүүгээр нөөцлөгдсөн байгаагаас үндэслэн бэлэн мөнгийг хэрэгцээнээс илүү сэлбэг, хэрэгсэл худалдан авахад их хэмжээгээр зарцуулж эргэлтийг сааруулж байна гэж үзэж байна. Тухайлбал: цахилгааны сэлбэгийн жилийн хэрэгцээ 12,000.0 орчим мянган төгрөг байхал үлдэгдэл 50,000.0 орчим мянган төгрөг, насосны сэлбэгийн хэрэгцээ 50,000.0 орчим мянган төгрөг байхад үлдэгдэл 130,000.0 орчим мянган төгрөг, сантехникийн сэлбэгийн хэрэгцээ 25,000.0 орчим мянган төгрөг байхад үлдэгдэл 65,000.0 орчим мянган төгрөг гэх мэт ойролцоогоор 3 орчим жилийн хэрэгцээг нөөцөлсөн байна. / дэлгэрэнгүйг хүснэгт -6-д үзүүлэв /

3.2.5 Бүртгэл тооцооны ажилтнуудын зүгээс тус компанийн санхүү, эдийн засаг, авлага, өр төлбөр, бэлэн мөнгөний эргэц, бараа материалын бэлтгэн нийлүүлэлт, зарцуулалт, ашиг, алдагдал, үр дүн зэрэгт санхүүгийн шинжилгээ огт хийгдэхгүй байна.

3.3 Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шугам, сүлжээний угсралтын ажлыг бүртгэлд тусгаагүй, эргэлтийн хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

3.3.1 “Гавшгай ус” ХХК нь 2015 онд 46,300.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авч бүртгэсэн бөгөөд хөрөнгө, хангамжийн материал акталж данс бүртгэлээс хасаагүй байна.

3.3.2 Тайлант хугацаанд худалдан авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого, зарлагыг бүртгэлд бүрэн тусгасан боловч улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шугам, сүлжээний угсралт, засварын ажлуудыг бүртгэлд тусгаагүй байна.

3.3.3 2014 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,389,672.7 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хөтөл хотын доторх инженерийн шугам сүлжээний угсралтын ажил” 2014-2015 оны хооронд гүйцэтгэгдэж уг ажлыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2015 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 24/2015 тоот актаар хүлээн авч ашиглагч байгууллага болох “Гавшгай Ус” ХХК-нд хүлээлгэн өгсөн боловч бүртгэлд тусгаагүй байна.

3.3.4 2015 онд Сайхан сумын хөрөнгө оруулалтаар хийгдсэн 79,804.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөтөл хотын инженерийн шугам сүлжээний хэсэгчилсэн ТК8-ТК хүртэлх засварын ажил”-ыг капиталжуулж бүртгээгүй байна.

3.3.5 Гүйцэтгэх захирлын 2015 оны 12-р сарын 09-ний өдрийн 105 тоот тушаалаар тооллогын комисс томилон үндсэн болон эргэлтийн хөрөнгийн жилийн эцсийн тооллого явуулж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулсан байна. Гэвч эргэлтийн хөрөнгийн тооллогыг жилийн эцэст нэг удаа хийж байгаа нь ТБОНӨ-ийн тухай

хуулийн 70.2⁷ дах заалтай нийцээгүй бөгөөд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тавих дотоод хяналтыг сулруулах эрсдлийг үүсгэж байна.

Илэрсэн зөрчил

Аудитаар дараах зөрчлүүдэд акт, албан шаардлага бичигдлээ. Үүнд:

Акт

- Ажилтнуудад албан томилолтын зардлыг олгохдоо “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчилэн тогтоох” тухай Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалыг зөрчин зам хоног, байрны зардлыг олгосон боловч нэмж зочид буудлын зардлыг 1,905.1 мянган төгрөгөөр илүү олгосон, */дэлгэрэнгүйг хавсралт 3-д үзүүлэв/*
- Компанийн удирдлагуудтай холбоотойгоор 2009-2015 онд үүссэн боловч өнөөг хүртэл барагдуулаагүй авлага 27,580.8 мянган төгрөг / цалингийн урьдчилгааны 9,550.8 мянган төгрөг, хүнсний материал, цементийн авлага 18,030.0 мянган төгрөг / зэрэг нийт 29,485.9 мянган төгрөгийн төлбөрийн акт,

Албан шаардлага

- Байгууллагын зардлыг хэмнэж үр ашгийг сайжруулах хүрээнд тэвчиж болох нийт 4,090.1 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан,
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар нийт 4,650.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, */дэлгэрэнгүйг хавсралт 2-д үзүүлэв/*
- Ажилтнуудад албан томилолтын зардал олгохдоо “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчилэн тогтоох” тухай Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалыг зөрчин албан томилолтын үнэмлэх, томилолтоор ажилласан эсэхийг нотлох, дэмжих баримтгүйгээр 3,253.3 мянган төгрөгийн зам хоног, байрны зардлыг олгосон */дэлгэрэнгүйг хавсралт 3-д үзүүлэв/*
- Байгууллагын хөрөнгө, санхүүгийн нөөцийг зохистой удирдаагүй мөн бүртгэлээр тавих хяналт сул байснаас нийт авлагын 27 % буюу 287,648.6 мянган төгрөгийн байгууллага, хувь хүн, ажилчдаас авах цалингийн авлагын дансанд насжилт өндөртэй авлага үүсгэснийг барагдуулах, / дэлгэрэнгүйг хавсралтаар үзүүлэв /
- Худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг зөрчин нийт 202,069.7 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн зэрэг нийт 501,711.7 мянган төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага бичигдлээ.
- Тус компанийн үйл ажиллагаанд аймгийн Аудитын газраас хийж гүйцэтгэсэн удаа дараагийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс

⁷ 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;

компанийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, их хэмжээний авлага, өглөг үүсгэсэн, санхүүгийн зөрчил гаргасан гүйцэтгэх захирал Л.Балдорж, ерөнхий нягтлан бодогч О.Буянаа, нягтлан бодогч И.Цэвэлмаа, М.Оюун, кассын нярав М.Оюунбаяр нарт ажлын хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэх.

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

“Гавшгай-ус” ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод хяналт сул байснаас их хэмжээний авлага, өглөг хуримтлагдаж, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж улам бүр алдагдсаар байна.

- ❖ *Эрчим хүчний тухай хуулийг зөрчин дулаанаар зохицуулалттайгаар хангах тусгай зөвшөөрөлгүйгээр дулаан дамжуулан борлуулж байгаа бөгөөд тус компанийн үйл ажиллагааг аймгийн ИТХ-д тайлагнаагүй байна.*
- ❖ *Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт алдагдснаас хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулж, авлага, өглөг их хэмжээгээр өссөн байна.*
- ❖ *Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, эргэлтийн хөрөнгийг хуулийн хугацаанд тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.*

Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүдэд:

- ✓ Жил бүр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хүргүүлж, хэлэлцүүлж байх,
- ✓ ТУЗ-ийн зүгээс компанийн санхүүгийн үйл ажиллагаанд бодит хяналт, шалгалт хийж өглөг, авлагыг бууруулах арга хэмжээг авч ажиллах,
- ✓ Зөвхөн санхүүгийн тайлан дээрх, мөнгө нь орж ирээгүй ашгийг үндэслэн компанийн захиралд урамшуулал олгох тогтолцоог өөрчлөх, захирлын ажлын үзүүлэлтэд өглөг, авлага барагдуулалт, санхүүгийн зөрчил, холбогдох хяналтын байгууллагуудын үнэлэлт дүгнэлтийг авч үзэж байх.

Аймгийн ИТХ-ын дарга болон Засаг дарга нарт :

- ✓ “Гавшгай-Ус” ХХК-ийн ТУЗ-ийг шинэчлэн зохион байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч байх.

- ✓ “Гавшгай-Ус” ХХК-ийн удирдлагатай жил бүр гэрээ байгуулж бодитоор дүгнэж байх, компанийн санхүүгийн нөхцөл байдлыг хүндрүүлсэн, их хэмжээний санхүүгийн зөрчил гаргасан гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт хариуцлага тооцох.
- ✓ “Гавшгай-Ус” ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, нөхцөл байдалд нь санхүүгийн шинжилгээ хийж цаашид хэрэгжүүлэх арга замыг бодитоор тодорхойлох.

Гүйцэтгэх захирал Л.Балдоржид:

- ✓ Эрчим хүчний тухай хуулийг зөрчин дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлгүйгээр “Цемент шохой” ХК-ийн өмнөөс дулаан борлуулж буй үйл ажиллагааг хууль, эрхийн актад нийцүүлэх,
- ✓ Компанийн ойрын болон хэтийн бизнес стратегийн төлөвлөгөөг боловсруулж, түүний гүйцэтгэлийг үнэлж дүгнэх замаар үйлдвэрлэл, үйл ажиллагааг үр ашигтай эрхлэх.
- ✓ Хөрөнгийн зарцуулалтад үр ашиг, арвилан хэмнэлттэй байх зарчмыг баримталж, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах,
- ✓ Олон жилийн насжилттай авлагыг барагдуулж, өглөгийг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд биечлэн хяналт тавьж ажиллах, хуулийн байгууллагад шилжүүлэх,
- ✓ Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллах ,
- ✓ Бараа материал, үүний дотор сэлбэг хэрэгслийг хэрэгцээнээс хэт ихээр нөөцөлж, мөнгөний эргэлтийг сааруулж буй зөрчлийг таслан зогсоох,
- ✓ Компанийн ажилтнуудтай холбоотой үүссэн авлагыг нэн даруй барагдуулж, компанийг хохиролгүй болгох.

Эдийн засагч Ё.Батцэнгэл, Ерөнхий нягтлан бодогч О.Буянаа, тооцооны нягтлан бодогч, эд хариуцагч нарт.

- ✓ Санхүүгийн тайлан, мэдээнд санхүүгийн шинжилгээ хийж авлага барагдуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх,
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1,389,672.7 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хөтөл хотын доторх инженерийн шугам сүлжээний угсралтын ажил”, Сайхан сумын хөрөнгө оруулалтаар хийгдсэн 79,804.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөтөл хотын инженерийн шугам сүлжээний хэсэгчилсэн ТК8-ТК хүртэлх засварын ажил” зэрэг хөрөнгө оруулалтын ажлуудыг капиталжуулж хөрөнгийн бүртгэлд тусгах,
- ✓ Эргэлтийн хөрөнгийн тооллогыг ТБОНӨТухай хуульд заасны дагуу жилд 2 удаа хийж үлдэгдлийг баталгаажуулж байх,
- ✓ НББ-ийн программыг НББОУС-тад нийцүүлэн шинэчлэх,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АХЛАХ АУДИТОР

С.БАТ-ЭРДЭНЭ

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМ
“ГАВШГАЙ-УС” ХХКОМПАНИ**

2056194 Хөтөл, Сайхан сум
Утас: 70368354, Факс: 70368354
E-мэйл: Hutulgavshgaius@yahoo.com

2016.08.10 № 97

Танай 2016.07.29 ны № 121

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч. ЭНХТУЯА ТАНАА**

Аймгийн аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн,
ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Гавшгай-Ус”
ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал
хүргүүлэв.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


Л. БАЛДОРЖ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн аудитын газрын 2016 оны бүтээгдхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлангийн төслийг уншиж танилцлаа.

Үйл ажиллагааны зардлыг хууль, журмын дагуу зарцуулсан эсэх талаар гаргасан танай байгууллагын дүгнэлтүүдтэй санал нэг байна.

Байгууллагын зардлын үр ашигтай байдлыг сайжруулах хүрээнд зайлшгүй гарах ёсгүй, компаний үйл ажиллагаанд хамааралгүй, хандивын шинжтэй гүйлгээнүүдийг гаргахгүй, ННБ-ийн хуульд гийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

Цаашид мөнгөн хөрөнгийн зарцуултанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, анхан шатны баримтгүй, үр ашиггүй зардал гарах эрсдлүүдийг үүсгэхгүйгээр ажиллана

Авлагын талаар:

2015 оны жилийн эцсийн авлагыг 2016 оны өнөөгийн авлагатай харьцуулахад 13,2 %-иар өссөн байдалд дүгнэлт хийж авлага үүсгэхгүй тал дээр анхаарч өмнө зохион байгуулж байсан арга хэмжээгээ сайжруулж үр дүнд хүргэн ажиллана. Үйл ажиллагаа явуулж, борлуулалт нэмэгдэх тусам авлага дагаж нэмэгддэг сөрөг үр дагаврыг таслан зогсооно

. Авлага нэмэгдэж байгаа нь компанийн тулгамдсан асуудал болоод байгааг хүлээн зөвшөөрч байна.

Борлуулалтын орлогоо төвлөрүүлэх тал дээр гол анхаарлаа хандуулан, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай мөнгөн хөрөнгийн эргэлтийг түргэсгэж, авлагын дэлгэрэнгүй судалгааг үндэслэн өмнө нь авлага, бууруулах талаар хийж байсан ажлаа эрчимжүүлэн шат дараатайгаар авлагыг бууруулан ажиллана.

Байгууллагын удирдлага, бүртгэл тооцооны ажилтнуудын зүгээс хөрөнгө, санхүүгийн нөөцийг зөв зохистой удирдаагүй, бүртгэлээр тавих хяналт сул

байснаас авлага өсч байгаад дүгнэлт хийж зарим санхүү бүртгэлийн ажилчдын хамтын хөдөлмөрийн гэрээг цуцлан хариуцлага тооцон ажиллаж байгаагийн дээр бүтэц орон тооны оновчтой хэлбэрийг судлан ажиллаж байна. .

. Цалингийн урьдчилгааг тайлант жилд багтаан суутгаагүйгээс авлага үүсч байгаад дүгнэлт хийж дахин ийм зөрчил гаргахгүй ажиллахыг цалин хөлсний нягтлан бодогч үүрэг болголоо.

Байгууллагаас авах борлуулалтын орлогын авлагын 31 хувийг Цемент шохой" ХК-аас авах авлага эзэлдэг бөгөөд барилгын салбарын үйл ажиллагааны доголдолтой холбогдон төлөлт сайжрахгүй хүндрэл үүсч байгаад дүгнэлт хийн гэрээнийхээ заалтанд өөрчлөлт оруулахаар санал хүргүүлээд байна .

Өглөгийн талаар:

2016 оны 04-р сарын байдлаар нийт өглөгийн 4 хувийг байгууллагад төлөх өглөг, 7.9 хувийг цалингийн өглөг, 36.9 хувийг татварын өглөг, 46.2 хувийг НДШ-ийн өглөг, 5 хувийг бусад өглөг тус тус эзэлж байгаа нь НДШ-ийг төлөхгүй өр үүсгэх, улмаар хуулийн дагуу тэтгэвэр тэтгэмж тогтоолгож чадахгүй байх, банкны хэрэглээний зээл авч чадахгүй байх зэргээр ажилтнуудын нийгмийн асуудалд сөргөөр нөлөөлж байгаа асуудлыг борлуулалтын орлогоо цаг хугацаанд нь төвлөрүүлэх, авлагаа бууруулах замаар шийдвэрлэх болно.

Тус байгууллагын зарим ажил гүйлгээ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1¹, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн 2 дахь² заалтыг тус тус зөрчсөн гэсэн дүгнэлт гарсан бөгөөд тухайн орон нутаг, ААНэгж хоорондын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан зайлшгүй байдлаар хийгдсэн гүйлгээнүүд болохыг тайлбарласан болно.

Цаашид хөрөнгө, материалын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажиллана.

Компаний санхүү, эдийн засаг, авлага, өр төлбөр, бэлэн мөнгөний эргэц, бараа материалын бэлтгэн нийлүүлэлт, зарцуулалт, ашиг, алдагдал, үр дүн зэрэгт бүртгэл тооцооны ажилчдын зүгээс санхүүгийн шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллах зайлшгүй шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шугам, сүлжээний угсралтын болон засварын ажлуудыг тус аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу бүртгэл тооцоонд тусгаад байна.

Компаний удирдах бүрэлдэхүүнд ажилладаг албан тушаалтнуудын -ТУЗ-ын дарга Ж.Санжжав 2,057.0 мянган төгрөгийн, ерөнхий нягтлан бодогч О.Буянаа 1,530.2 мянган төгрөгийн, нягтлан бодогч М.Оюун 1,883.4 мянган төгрөгийн, кассын нярав М.Оюунбаяр 6,137.2 мянган төгрөгийн зэрэг 2012-2015 онд үүссэн нийт 11,607.8 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагыг барагдуулаагүй

-Ерөнхий нягтлан бодогч О.Буянаагийн 2009 онд үүссэн 4,056.8 мянган төгрөгийн хүнс,цементний, кассын нярав М.Оюунбаярын 2012 онд үүссэн 6,893.3 мянган төгрөгийн хүнс, цементний, ерөнхий инженер С.Хамсандоржийн 2012 онд үүссэн 3,763.5 мянган төгрөгийн цементний, хүний нөөцийн ажилтан Д.Лхагвасүрэнгийн 2007 онд үүссэн 3,316.4 мянган төгрөгийн зэрэг нийт 18,030.0 мянган төгрөгийн авлагуудын актуудыг, албан шаардлага болгон заасан хугацаанд барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг санал болгож байгааг минь хүлээн авч шийдвэрлэж өгөхийг хүсье.

Албан томилолтын зардлыг олгохдоо 2011 оны 132 тушаалыг зөрчиж нотлох дэмжих баримтгүйгээр 3,253.3 мянган төгрөгийн, зам хоног, байрны зардлыг олгосон боловч нэмж зочид буудлын зардлыг 1,905.1 мянган төгрөгөөр илүү олгосон, мөн касснаас анхан шатны баримтын бүрдэл дутуу, зардлын зориулалт тодорхой бус нийт 2,060.0 төгрөгийн зарлагын гүйлгээг гаргасан зэрэг нь манай санхүүгийн ажилчдын хариуцлагагүй үйл ажиллагаанаас улбаатайд дүгнэлт хийж цалингийн арга хэмжээ авахаар компанийн гүйцэтгэх захирлын тушаал

төлөвлөгдөөд байна. Бид илэрсэн зөрчлийг цаг тухайд нь барагдуулан ажиллах тул тус гүйлгээнүүд дээр тавигдсан актуудыг мөн албан шаардлага болгох саналтай байна.

Шалгалтын явцад гарч байгаа байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны талаарх илэрсэн зөрчил дутагдал, дүгнэлтүүдтэй санал нэг байна.

Цаашид хийгдэх ёстой ажлуудыг тус Аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу гүйцэтгэх болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ.....Л.БАЛДОРЖ

ЕРӨНХИЙ НЯ-БО.....О.БУЯНАА



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

- Аудитын тайлангийн төслийн гуравдугаар бүлгийн 3.1-дэх хэсэгт “Цемент шохой” ХХК-д борлуулсан усны орлогыг цаг хугацаанд нь төвлөрүүлж чаддаггүй байдлаас шалтгаалан компани хоорондын тооцоогоор 133,868.4 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэхдээ үнийн харьцуулалт хийлгүйгээр шууд гэрээ байгуулсан байна. Мөн 2015 онд 54,063.4 мянган төгрөгийн, 2016 оны 4-р сарын байдлаар 14,138.2 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэсэн байна. Эдгээр зөрчил нь МУ-ын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2 дахь заалтыг тус тус зөрчсөн* байна гэжээ.

ТАЙЛБАР: Энэ нь “Цемент шохой” ХХК нь усны төлбөрийг тогтмол хугацаанд төлдөггүй байдлаас шалтгаалж хоорондын тооцоогоор автомашин болон нүүрсний худалдан авалтыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн. Сайхан суманд үйл ажиллагаа явуулж байгаа ШТС-ууд нь манай байгууллагад зээлээр худалдан борлуулалт хийхгүй гэсэн шалтгаанаар гэрээ байгуулахаас татгалзсан тул шатахууны худалдан авалтыг үнийн харьцуулалт хийлгүйгээр гүйцэтгэсэн болно.

Аймгийн Аудитын газрын тайлбар:

Дээрх зөрчлүүд нь МУ-ын ТБОНӨХБАҮХТхуулийн 8.2 дахь *“Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”*, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2 дахь заалтуудыг тус тус зөрчиж* байна.

Хэдийгээр дээрх хүндрэл шалтгаанууд байгаа боловч аль болох холбогдох хууль, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулах бодлого барьж, үүссэн их хэмжээний авлагыг барагдуулсан тохиолдолд худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулах бүрэн үндэслэлтэй юм.

- Аудитын тайлангийн төслийн хоёрдугаар бүлгийн 2.3 дахь хэсэгт авлагын дансанд авлага барагдуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий тус компаний удирдах бүрэлдэхүүнд ажилладаг албан тушаалтнуудаас авах авлага ч тодорхой хувийг эзэлж байна. Тухайлбал:

- ТУЗ-ын дарга Ж.Санжжав 2,057.0 мянган төгрөгийн, ерөнхий нягтлан бодогч О.Буянаа 1,530.2 мянган төгрөгийн, нягтлан бодогч М.Оюун 1,883.4 мянган төгрөгийн, кассын нярав М.Оюунбаяр 6,137.2 мянган төгрөгийн зэрэг 2012-2015 онд үүссэн нийт 11,607.8 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагыг барагдуулаагүй байна.

-Ерөнхий нягтлан бодогч О.Буянаагийн 2009 онд үүссэн 4,056.8 мянган төгрөгийн хүнс, цементний, кассын нярав М.Оюунбаярын 2012 онд үүссэн 6,893.3 мянган төгрөгийн хүнс, цементний, ерөнхий инженер С.Хамсандоржийн 2012 онд үүссэн 3,763.5 мянган төгрөгийн цементний, хүний нөөцийн ажилтан Д.Лхагвасүрэнгийн 2007 онд үүссэн 3,316.4 мянган төгрөгийн зэрэг нийт 18,030.0 мянган төгрөгийн авлагуудыг өнөөг хүртэл барагдуулаагүй байна гэж үзээд төлбөрийн акт тогтоосон байна.

ТАЙЛБАР: Дээрх актуудыг албан шаардлага болгон заасан хугацаанд барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг санал болгож байгааг минь хүлээн авч шийдвэрлэж өгөхийг хүсье.

Аймгийн Аудитын газрын тайлбар:

Аймгийн аудитын газраас 2013 онд хийсэн эрсдэлийн аудитаар компаний эрх бүхий албан тушаалтнуудтай холбоотой их хэмжээний авлага үүссэн байсан тул төлбөрийн акт тогтоож авлагыг төлүүлж байсан боловч дээрх алдааг давтан гаргаж авлага үүсгэн, удаа дараагийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс аудитын үр нөлөөг алдагдуулж байна.

ТУЗ-ийн дарга Ж.Санжжавтай холбоотой үүссэн 2,057.0 мянган төгрөгийн авлага нь бүртгэлийн буруу бичилтийн улмаас хаагдаагүй байсныг залруулан тайлангийн дээрх хэсэг болон актын дүнгээс хасч, бусад 27,580.8 мянган төгрөгийн төлбөрийн актыг хэвээр үлдээв.

- **Аудитын тайлангийн төслийн 2 дугаар бүлгийн 2.2 дахь хэсэгт:**

А/ Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар нийт 4,650.0 мянган төгрөгийн, зардлын зориулалт тодорхой бус нийт 2,060.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна. /дэлгэрэнгүйг хавсралт 2-д үзүүлэв/ Эдгээр зөрчил нь НББ-ийн тухай хуулийн 7.1, 7.7 дахь заалтуудыг зөрчиж байна.

Б/ Ажилтнуудад албан томилолтын зардлыг олгохдоо “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчилэн тогтоох” тухай Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалыг зөрчин албан томилолтын үнэмлэх, томилолтоор ажилласан эсэхийг нотлох, дэмжих баримтгүйгээр **3,253.3** мянган төгрөгийг, зам хоног, байрны зардалд олгосон боловч нэмж зочид буудлын зардлыг **1,905.1** мянган төгрөгөөр илүү олгосон байна /дэлгэрэнгүйг хавсралт 3-д үзүүлэв/ гэж үзээд төлбөрийн акт тогтоосон байна.

ТАЙЛБАР: Эдгээр зөрчил нь манай санхүүгийн ажилчдын хариуцлагагүй үйл ажиллагаанаас улбаатайд дүгнэлт хийж цалингийн арга хэмжээ авахаар компанийн гүйцэтгэх захиралын тушаал төлөвлөгдөөд байна. Бид илэрсэн зөрчлийг цаг тухайд нь барагдуулан ажиллах тул тус гүйлгээнүүд дээр тавигдсан актуудыг мөн албан шаардлага болгох саналтай байна.

Аймгийн Аудитын газрын тайлбар:

Аймгийн аудитын газраас 2013 онд хийсэн эрсдэлийн аудитаар кассаас анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гаргаж, бүртгэлд тусгасан алдаа,

зөрчил илэрч байсан бөгөөд аудитаар зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн боловч дээрх алдаа зөрчлийг арилгаагүй, давтан гаргасаар байна. Албан томилолтын зардлыг олгохдоо Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалд заасан хэмжээнээс хэтрүүлэн олгосон, албан томилолтоор ажилласан эсэх нь тодорхойгүй дэмжих баримтгүй байсан болно.

Иймд зардлын зориулалт тодорхой бус ямар нэгэн дэмжих баримтгүйгээр кассаас зарлага хийсэн 2,060.0 мянган төгрөгийн гүйлгээний холбогдох баримтуудыг бүрдүүлж хянуулсан тул уг алдааг аудитын тайлангийн 2 дугаар бүлгийн 2.2 дахь хэсэг болон төлбөрийн актын дүнгээс хасахаар, анхан шатны баримтгүй олгосон 3,253.3 мянган төгрөгийн зөрчлийг актын дүнгээс хасч албан шаардлага өгөхөөр тус тус шийдвэрлэв.

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР